

ЕВРОПЫН ХОЛБООТ ОЙН ТҮНШЛЭЛ Монгол Улс

#GlobalGateway #ForOurPlanet

Монгол орны ойг хадгалан үлдээх цогц арга хэмжээ



Эх дэлхий болон хүн төрөлхтөн хоорондын тогтвортой харилцааг бэхжүүлэх зорилготой Европын Холбоо (ЕХ)-ны Global Gateway стратегийн хүрээнд Монгол Улс болон Европын Холбоо нь ойн доройтол, цөлжилт, уур амьсгалын өөрчлөлт, биологийн олон янз байдлын хомсдол зэрэг сорилтыг хамтран шийдвэрлэхийн сацуу Монгол Улсын үндэсний тогтвортой, хүртээмжтэй хөгжилд ой салбарын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна.

Ойн Түншлэлийн үндсэн чиглэл

- Ойн засаглалыг бэхжүүлэх
- Ойн тогтвортой менежмент ба ойд суурилсан нэмүү өртгийн сүлжээ
- Ойн хомсдол, доройтлыг бууруулах
- Байгалийн ойг хамгаалах, нөхөн сэргээх
- Үр дүнтэй санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Газар нутаг	157 сая га
Хүн ам	3.5 сая
Нягтшил	2 хүн / км ²
ДНБ-ний өсөлт (2024)	4.9%



Ойн тухай товч мэдээлэл

8.45%	Нийт газар нутгийн ойгоор бүрхэгдсэн талбай
83.5%	Хамгаалалтай ойн талбай (16 сая га)
1.25%	1990 оноос хойш хомсодсон ойн хэмжээ
0.3%	ДНБ дэх ойн салбарын хувь хэмжээ
80,000	Ойтой холбоотой ажлын байр

SOURCES: FAO FRA 2020, FAOSTAT 2020

Монгол Улсын Засгийн газрын зорилт

Монгол Улс байгаль, хэл, хил, соёлоо тогтвортой хамгаалах

2030 он хүртэл үндэсний хэмжээнд тэрбум мод тарих

Ойн хомсдолыг 31%-иар бууруулах

Ойн доройтлыг 25%-аар бууруулах

Тогтвортой ойн менежменттэй талбайг 6.5-аас 9.8 сая га хүртэл нэмэгдүүлнэ.

Нүүрстөрөгчийн хийн ялгарлыг 16.9 сая тонноор бууруулах

Тусгай хамгаалалттай бүс нутгийн хил хязгаар, уялдаа холбооны зохицуулалтыг бэхжүүлэх



Ойн Түншлэлийн хөрөнгө оруулалт

- Ойг их хэмжээгээр нөхөн сэргээх
- Мод боловсруулах салбарын шинэчлэл
- Ой мод, аялал жуулчлалын чиглэлээр зохистой ашиглалтыг дэмжих дэд бүтцийг бүрдүүлэх
- Ойн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх

ЭХ СУРВАЛЖ: Алсын хараа 2050, Монгол Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН), төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан Тэрбум мод тарих үндэсний хөтөлбөр, Ерөнхийлөгчийн зарлиг 2021.



Хүмүүс ба ой мод

Монгол Улстай хамтарсан “Ойн түншлэл” нь ойн экосистемийн хамгаалал, тогтвортой менежментийг нөөцийн хариуцлагатай ашиглалт, боловсруулалттай хослуулан хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэд, хувийн хэвшлийн оролцоог дэмжин ажилладаг. Монгол орны нийт ойн 71 хувийг төрийн байгууллага удирдан зохион байгуулдаг бол 25 хувийг ойн нөхөрлөл, 4 хувийг ойн мэргэжлийн аж ахуйн нэгжүүд хариуцан ажилладаг байна. Монголчуудын хувьд ой мод нь гүн гүнзгий соёлын болон сүсэг бишрэлийн үнэ цэн, ач холбогдолтойгоос гадна үндэсний ижилсэл, оршихуйтай салшгүй холбоотой юм. Энэхүү үнэт өв, уламжлалыг хариуцлагатай эдийн засгийн боломжтой уялдуулж буй нь ойн салбарын тогтвортой хөгжил болон хүмүүсийн амь амьдралд ашиг тусаа өгч байна. Энэ боломжийг бүрэн нээхэд хувийн хэвшлийн оролцоо чухал бөгөөд тогтвортой нөөцийг бүрдүүлэх, боловсруулах үйлдвэрлэл, инновацад хөрөнгө оруулах шаардлагатай. Ойд суурилсан нэмүү өртгийн сүлжээ болон ногоон бизнесийг бэхжүүлэх нь бүс, орон нутгийн хөгжилд түлхэц өгч, байгаль, соёлын өвийг хадгалж, импортын хамаарлыг бууруулах ач холбогдолтой билээ.

Монгол Улсын ойн салбар

Монгол орны хойд хэсэгт 11,3 сая га талбайд **сэрүүн бүсийн шилмүүст ой** (шинэс, хус, хуш, нарс, улиас, гацуур) зонхилно. Харин өмнөд бүсийн хэт хуурай нөхцөлд орших **заган ой** 2.6 сая га талбайг эзэлж байна. Гэвч ойн салбар ДНБ-ий 0.3% л бүрдүүлж байгаа нь эдийн засаг талаасаа тус салбарын алдагдсан боломжийг харуулж байна. Монгол Улс мод импортлогч орон хэдий ч ой модны салбар 80,000 шууд болон шууд бус ажлын байр бий болгож байна. Иймд байгаль орчны бодлогын хүрээнд зөвхөн хамгаалал төвтэй менежментээс тогтвортой бөгөөд хариуцлагатай ашиглалт, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд шилжих үйл явц нь институтын тогтолцоог бэхжүүлэх, бизнесийн орчныг сайжруулах, импортыг бууруулах, экспортыг нэмэгдүүлэх, ойн нөхөн сэргээлт, тусгай хамгаалалттай газар нутагт ойн менежментийг өргөжүүлэх, ойн доройтол болон түймрийн хяналтыг сайжруулах, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхийг хамрах юм.



Монгол гэр

Монголчуудын хувьд Монгол гэр, морин хуур, сийлбэртэй эмээл, ёслолын хэрэгслүүдийг Монгол орны уугуул модоор урлан, үеэс үед өвлүүлэн хэрэглэж ирсэн уламжлалтай. ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтөний биет бус соёлын өвд бүртгэгдсэн Монгол гэр нь өнөөдөр Монгол Улсын экспортын гол модон бүтээгдэхүүн бөгөөд жилээс жилд худалдаа, хэрэглээ нэмэгдэж буй нь нэмүү өртөг шингэсэн ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл цаашид ч хөгжих боломжийг харуулж байна.

Ойгоо түшиглэж,
Ирээдүйгээ бүтээе



ЕХ-ны Олон улсын хамтын
ажиллагааны газар – Ойн хэлтэс